

ТАНИЛЦУУЛГА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН “ЗААВАР ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” ХАМТАРСАН ТУШААЛЫН ТӨСӨЛ

2020 оны 04 дүгээр сарын 20

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв, салбар, орон нутгийн комисс нь иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлахдаа Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Заавар шинэчлэн батлах тухай” А/85/241 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Шүүхээр ял эдэлж байгаа хоригдлын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох талаар холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байгаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаагаа сунгуулаагүй иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлах эсэх зэрэг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох үйл ажиллагаанд тодорхойгүй асуудлууд байна.

Иймд эмнэлэг хөдөлмөр магадлалын үйл ажиллагааг боловсронгуй болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэн (даатгуулагч)-д хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөр зохицуулалт хийх үйл ажиллагаанд гарч буй маргаантай асуудлыг шийдвэрлэх эрхзүйн орчныг боловсронгуй болгох, магадлалын үйлчилгээнд оролцогч талуудад чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх зорилгоор дараах нэмэлт өөрчлөлтийг тусган шинэчлэн боловсруулав. Уг тушаалын зааврын төсөлд шинээр 7 заалт, өөрчлөн найруулсан 5 заалтыг тус тус тусгалаа. Үүнд:

- Орон нутгийн комисс болон салбар ЭХМК нь 7-9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар Засгийн газрын “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2015 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д заасан боловч орлогч дарга ямар албан тушаалтан байхыг заагаагүй тул “...Орлогч дарга нь аймаг /дүүрэг/-ийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч..” байхаар;
- ЭХМК-ын гишүүдийн ирц гуравны хоёрт хүрээгүй тохиолдолд тухайн өдрийн хурлын шийдвэр хүчингүйд тооцохоор;
- Иргэний эрүүл мэндийн байдлыг идэвхтэй хяналтад 3 сар хүртэлх хугацаанд хянаж хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож байсныг 3-6 сар болгон өөрчлөхөөр;
- Хорт хавдар, гэмтлийн өвчний үе шат, хүндрэлээс хамааран хяналтын хугацаа хамаарахгүйгээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоохоор;
- Хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоохдоо ЭХМК-ын хурлын шийдвэр гарсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар алдалт эхлэх хугацааг тооцохоор;
- Иргэний хүсэлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг тогтоосон хугацаанаас 14 хоногийн өмнө эсвэл хойно комиссын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаа сунгах асуудлыг хэлэлцүүлж болохоор;

- Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хувь хугацаа хүчинтэй хугацаанд өвчний хүндрэл, үе шатыг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг дахин магадлан өөрчилж болохоор;
- Иргэн (даатгуулагч) нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоосон хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор магадлуулаагүй тохиолдолд иргэн (даатгуулагч)-д мэдэгдсэний үндсэн дээр цуцлах шийдвэрийг гаргаж байхаар;
- Иргэн (Даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг зарим өвчний оношийн үед цахим хэлбэрээр сунгаж иргэнийг чирэгдүүлэхгүй ажиллаж байхаар;
- Шүүхээр ял эдэлж буй ялтанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг Хорихын нэгдсэн эмнэлгийн Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрийг үндэслэн хорих байгууллагын харьяа аймаг (дүүрэг)-ийн ЭХМК шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хорих ангийн харьяа орон нутгийн нэгдсэн эмнэлгийн ЭХК-ын саналыг үндэслэн шийдвэрлэж ажилласнаар зохицуулах зэрэг тус тус болно.

Энэхүү “Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар”-ыг шинэчлэн баталснаар Эмнэлэг хөдөлмөр магадлалын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, иргэн (даатгуулагч)-д Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааг чирэгдэлгүй хүргэх боломжтой болно.

---oo0oo---

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны....дугаар
сарын-ны өдөр

Дугаар/.....

Улаанбаатар
хот

Заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 203 дугаар зүйлийн 203.2.4 дэх хэсэг, 204 дүгээр зүйлийн 204.1.3 дахь хэсэг, 210 дугаар зүйлийн 210.1.8 дахь хэсэг, Засгийн газрын “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2015 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган уг тушаалыг хэрэгжүүлж, ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаалаар баталсан зааврыг мөрдөн ажиллахыг Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, эмнэлгийн байгууллагуудын Эмнэлэг хяналтын комисст тус тус даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/, Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т тус тус үүрэг болгосугай.

5.Энэ тушаалыг баталсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/85/241 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Д.САРАНГЭРЭЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Эрүүл мэндийн сайдын 2020 оны
дугаар сарын-ны өдрийн
дугаар хамтарсан тушаалын хавсралт

ИРГЭН (ДААТГУУЛАГЧ)-ИЙ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ХУВЬ ТОГТООХ, ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ЗААВАР

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (цаашид “ЭХМК” гэх) нь иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас (хэсэгчлэн) алдсан шалтгаан, хувь, хугацаа тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах асуудлыг магадлан шийдвэрлэхэд энэхүү зааврыг баримтална.

1.2.Аймаг, дүүргийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комисс, Хорих ял эдлүүлэх албаны нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комисс (цаашид “ЭХК” гэх) болон эмнэлгийн мэргэжилтнүүд хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хянан хэлэлцэх, магадлах, тогтоох үйл ажиллагаандаа энэхүү “Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар” (цаашид “заавар” гэх)-ыг ашиглана.

1.3.Заавар нь иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалт (цаашид “ХЧА” гэх)-ыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах болон эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээхтэй холбоотой харилцаанд оролцогчид нэгэн ижил ойлголттой болох, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг ил тод нээлттэй хүргэхэд чиглэгдэнэ.

1.4.Ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувийг дараах үзүүлэлтүүдийг харгалзан тогтооно:

1.4.1.Өвчин гэмтэл нь архагшин эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагаа нь хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, байнга хэвтэрт, бусдын асаргаа сувилгаанд байдаг хүмүүст ХЧА-ыг 80-100 хувиар;

1.4.2.Өвчин эмгэг нь архагшин эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагаанд нь гүнзгий нөлөөлж, хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн буюу удаан хугацаагаар алдсан боловч байнгын асаргаа сувилгаа шаардахгүй ихэнхдээ өөрөө өөртөө үйлчлэх чадвартай өвчтөнд хөдөлмөрийн чадвар алдалтыг 70-79 хувиар;

1.4.3.Өвчин эмгэг нь архагшин эрхтэн бие махбодийн тогтоц, үйл ажиллагаанд удаан хугацаагаар нөлөөлж, хөдөлмөрийн чадвар нь алдагдсан боловч өвчтөн өөрөө өөртөө үйлчлэх чадвартай, өвчилж гэмтсэн эрхтэнд харшлахгүй ажлыг мэргэжлийн эмчийн хяналтын дор хийж болох иргэн (даатгуулагч)-д хөдөлмөрийн чадвар алдалтыг 50-69 хувиар тус тус тогтооно.

1.4.4.Хоёр буюу түүнээс дээш өвчнөөр өвчилсөн иргэний үндсэн өвчнийг сонгон ХЧА-ын хувийг тогтоох ба хавсарсан өвчний үе шат, явц, биеийн ерөнхий байдал зэргийг харгалзан үндсэн өвчний ХЧА-ын хувь дээр 5 /тав/ хүртэл хувийг нэмж тогтоож болно.

1.4.5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчийн ХЧА-ын хувь дээр ердийн өвчний хувийг нэмж тогтоохгүй.

1.4.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн ХЧА-ын хувийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн холбогдох заалт болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн ослын актыг үндэслэн тогтооно.

1.5. Иргэн (даатгуулагч)-ий биеийн эрүүл мэндийн байдал суларч, хөдөлмөрийн чадварын бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, дадаж мэргэшсэн ажлаа хөдөлмөрийн тогтоосон цагт тоо, чанарын хувьд бүрэн гүйцэтгэж чадахгүй болсон бол түүнийг биеэ сувилуулах, эмчлүүлэхэд нь зориулж, ажлын цагийг тодорхой хугацаагаар хорогдуулна.

1.6. Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн нөхцөл биеийн эрүүл мэндэд нь хортой нөлөө үзүүлж, өвчин эмгэг нь цаашид даамжран хүндрэх төлөвтэй бол түүний хөдөлмөрийн нөхцөлийг түр буюу бүрмөсөн сольж өөрчилнө.

1.7. ХЧА-ын хувь тогтоолгосон иргэн (даатгуулагч) нь ХЧА-ын хувиас хамаарахгүйгээр өөрийн биеийн байдал, өвчний үе шатанд нөлөөлөхгүй ажил, үйлчилгээ эрхэлж болно.

1.8. Хөдөлмөр зохицуулалт хийхэд зааврын 3,4,5 дахь хэсэгт заасан дарааллыг баримтална.

1.9. ЭХМК нь иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах асуудлыг шийдвэрлэхдээ түүний иргэний үнэмлэх, өвчтөний амбулаторийн карт, холбогдох шинжилгээнд үндэслэнэ.

Хоёр. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа

2.1. ЭХМК нь үйл ажиллагаандаа “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийг баримтална.

2.2. ЭХМК-ын хуралд дарга болон магадлагч эмч нэгэн зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй тохиолдолд уг хурлыг хойшлуулна.

2.3. ЭХМК-ын хуралд гишүүдийн ирц гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд уг хурлыг хойшлуулна.

2.4. ЭХМК-ын хурлын үед иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ыг магадлах явцад эргэлзээтэй, мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах шаардлага үүссэн тохиолдолд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоос мэргэжил арга зүйн зөвлөгөө авч болно.

2.5.ЭХМК нь магадлагч эмчид ЕМД-3, Health info, medsoft зэрэг програмаас иргэн (даатгуулагч)-ий биеийн байдал, оношлогоо, шинжилгээ, эмчилгээ, сувилгаа хийлгэсэн байдлыг хянах боломжийг бүрдүүлнэ.

2.6.ЭХМК нь 200 км-аас дээш зайд алслагдсан сум, суурин болон 3000-аас дээш хүн амтай сумын иргэн (даатгуулагч)-д эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх зорилгоор нүүдлийн хурал зохион байгуулж болно.

2.7.Энэ зааврын 2.6-д зааснаар зохион байгуулсан хурлаар иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг шинээр тогтоохгүй, зөвхөн сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, ажлын цагийг хорогдуулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.8.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гурав. Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагаа

3.1.Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч нь иргэн (даатгуулагч)-ий бие махбодийн тогтоц, үйл ажиллагаа алдагдсан байдлыг магадлах зорилгоор түүнийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, сэтгэцийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллагын төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээнд илгээнэ.

3.2.Мэргэжлээс шалтгаалсан өвчний үед аж ахуйн нэгж, байгууллагын эмч нь иргэн (даатгуулагч)-ийг мэргэжлээс шалтгаалсан өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллагын төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоо шинжилгээнд илгээж болно.

3.3.Эмчлэгч эмч нь нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтооход баримтлах өвчний жагсаалт” (цаашид “жагсаалт” гэх)-ын дагуу иргэн (даатгуулагч)-ий биеийн зовиур, өвчний түүх, бодит үзлэг, оношилгоо шинжилгээний өөрчлөлтүүд, төрөлжсөн мэргэжлийн эмчийн хариу, дүгнэлт, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчний онош, өвчний үе шат, ХЧА-ын хувь хэмжээ, хугацаа зэргийг тусгасан үечилсэн дүгнэлт бичиж ЭХК-т танилцуулна.

3.4.Сэтгэцийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллагад ирүүлсэн иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ыг тогтоох асуудлыг тухайн байгууллагын ЭХК, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дэргэдэх Сэтгэцийн өвчний болон мэргэжлээс шалтгаалсан өвчний Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссын хурлаар шийдвэрлэнэ.

3.5.Энэ зааврын 3.1, 3.2-т заасны дагуу илгээсэн иргэн (даатгуулагч)-ий биеийн байдал, үзлэг, оношлогоо, шинжилгээ, оношийг төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд баталгаажуулна.

3.6.Энэ зааврын 3.5-д заасны дагуу онош нь баталгаажсан иргэн (даатгуулагч)-ий өвчний явц, хүндрэл зэргээс шалтгаалан ХЧА-ын хувь, хугацаа тогтоох, хөдөлмөрийн нөхцөл солих саналыг ЭХК болон ЭХМК-ын хурлаар хэлэлцүүлж болно.

3.7.ЭХК нь тухайн иргэн (даатгуулагч)-ий үндсэн болон хавсарсан өвчний үзлэг, шинжилгээ, онош, өвчний үе шат, эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө, хяналтын хугацаанд хийсэн эмчилгээний үр дүнг судлан дүгнэж ба тухайн иргэн (даатгуулагч) ХЧА-ын шалтгаан, хувь хэмжээ, хугацаа тогтоолгох үндэслэлтэй бол ЭХМК-ын хуралд илгээнэ.

3.8.ЭХК-ын шийдвэрийг ЭХМК-ын гишүүдэд урьдчилан цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.9.ЭХК нь эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан “Эмнэлэг хяналтын комиссын дүрэм”-ийг баримтлан ажиллана.

3.10. Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төврүү илгээгээгүй болон ЭХК-ын хурлын дүгнэлт, шийдвэр гараагүй иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацаа тогтоох асуудлыг ЭХМК-ын хурлаар хэлэлцэн шийдвэрлэхгүй.

3.11.ЭХМК нь ЭХК-оос илгээсэн иргэн (даатгуулагч)-ий биеийн байдал, шинжилгээ, оношилгоо, онош, өвчний үе шатыг тодорхойлсон баримт бичигтэй танилцан дахин магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох үзлэг оношилгоог давтан хийсний дараа тухайн иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацааг тогтоох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

3.12.Хэрэв суманд ЭХМК-той бол сумын иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацаа тогтоолгох асуудлыг сумын эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч хариуцан шийдвэрлүүлнэ.

3.13.Эрхтэн системийн гүнзгий дутагдалтай, тээвэрлэх боломжгүй иргэн (даатгуулагч)-ий өвчний онош, үе шатыг бүрэн нотолсон эмчлэгч эмчийн үзлэг дүгнэлт, тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийн засаг, захиргааны байгууллагын тодорхойлолт, өөрсдийнх нь хүсэлт зэргийг үндэслэн ЭХМК-ын томилсон баг гэрийн үзлэг хийж, дүгнэлтийг ЭХМК-т хүргүүлснээр иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацааг тогтоох асуудлыг шийдвэрлэнэ.

3.14.Иргэн (даатгуулагч) хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол түүний ХЧА-ын хугацааг эхний удаад 3-24 сараар, хагас алдсан бол 3-12 сараар тус тус тогтооно.

3.15.Хэрэв өвчин эмгэг, гэмтлийн байдал нь хөдөлмөрийн чадвараа түр алдахад хүргэсэн бол идэвхтэй хяналтад 3-6 сар хүртэлх хугацаанд эмчлэн, эмчилгээний үр дүн, өвчний явцыг харгалзан ХЧА-ын хувь, хугацааг тогтоох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.16.Гэмтэл болон хорт хавдрын өвчний үед иргэн (даатгуулагч)-ий өвчний үе шат, хүндрэлийг харгалзан энэ зааврын 3.15-д заасан хугацааг баримтлахгүйгээр түүнд ХЧА-ын хувь, хугацааг тогтооно.

3.17.ХЧА-ын хувь, хугацааг шинээр тогтоохдоо ЭХМК-ын хурлын шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно.

3.18.Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэхгүй нь тогтоогдвол жагсаалтын дагуу түүний ХЧА-ыг хугацаагүйгээр тогтоож болно.

Дөрөв. Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг сунгах үйл ажиллагаа

4.1.ХЧА-ын хувь, хугацааг сунгах үйл ажиллагаанд энэ зааврын 3 дахь хэсэгт заасан дарааллыг баримтална.

4.2.Иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацааг сунгахдаа түүний хүсэлтийн дагуу ХЧА-ын хүчинтэй хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө эсвэл хойно ЭХМК-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэж болно.

4.3.Гадаад улсад удаан хугацаагаар эмчлүүлж байгаа иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг түүний оршин сууж буй газрын харъяа эмнэлэгт үзлэг, шинжилгээ, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хамрагдаж буй эсэх талаар эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь, тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газрын тодорхойлолт, иргэний хувийн хүсэлтийг тус тус үндэслэн ЭХМК шийдвэрлэнэ.

4.4.Иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь, хугацааг тогтоосон шийдвэр хүчинтэй байх хугацаанд өвчний үе шат, хүндрэлийг харгалзан дахин магадалж ХЧА-н хувь хэмжээ, хугацааг өөрчилж болно.

4.5.Иргэн (даатгуулагч) нь ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг тогтоосон хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор магадлуулаагүй тохиолдолд ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг цуцлах шийдвэр гаргана.

4.6.ЭХМК нь эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан "Иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг цахим хэлбэрээр тогтоох, сунгах өвчний жагсаалт"-ыг баримтлан иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг цахим хэлбэрээр сунгаж болно.

Тав. Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа

5.1.ЭХМК нь ЭХК-ын шийдвэрийг харгалзан олонхийн саналаар шийдвэр гаргана.

5.2.ЭХМК нь ХЧА-ын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон иргэн (даатгуулагч)-ийг хөдөлмөрийн чадвар алдсан өвчний оношоор эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээг авсан эсэхийг нийгмийн даатгалын ЭМД-3 программаас тулган шалгаж магадлан шийдвэрлэнэ.

5.3.ЭХМК-ын хурлын шийдвэр, ХЧА-ын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон иргэн (даатгуулагч)-ий үндсэн болон өөрчлөлт, хөдөлгөөний талаарх мэдээллийг цахим санд үнэн зөв бүртгэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын программаас хэвлэн гарын үсэг зурж баталгаажуулна.

5.4.Эмчлэгч эмчид өгсөн зөвлөмж, эмчилгээний үр дүн, түүнд тавих хяналт, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний чиглэл, төлөвлөгөө, дүгнэлт хангалтгүй иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ыг тогтоолгох, сунгуулахаар ЭХК-оос илгээсэн тохиолдолд уг шийдвэрийг ЭХМК буцаах арга хэмжээ авна.

5.5.ХЧА-ын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон иргэн (даатгуулагч)-ий өвчний онош, үе шат нь жагсаалтад дурдсан заалтад тохирохгүй, цуцлах үндэслэлтэй бол ЭХК нь эмчлэгч эмчид эмчилгээний чиглэл, зөвлөмж өгч, ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг цуцлах тухай шийдвэрийг ЭХМК-т илгээж, цуцалсан шийдвэр гаргуулна.

5.6.Хэрэв иргэн (даатгуулагч) нь эмчилгээ зөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хяналтын үзлэгт хамрагдаагүй тохиолдолд эмчлэгч эмч ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг бууруулах, цуцлах хүртэлх арга хэмжээний саналыг ЭХМК-т гаргаж болно.

5.7.ЭХМК нь хөдөлмөрийн чадвар алдалт, хөдөлмөр зохицуулалт хийсэн шийдвэрийг Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягт, загварт бичиж баталгаажуулна.

Зургаа.Бусад зүйл

6.1.ЭХМК-ын хурлаар ХЧА-ыг шийдвэрлүүлэх иргэн (даатгуулагч)-д тус комиссын нарийн бичгийн даргын гаргасан хурлын дарааллыг баримтална.

6.2. ЭХМК-ын нарийн бичгийн дарга нь иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ын хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын мэдээллийн нэгдсэн санд тухай бүрт үнэн зөв бүртгэнэ.

6.3.ЭХМК нь иргэн (даатгуулагч)-д ХЧА-аас урьдчилан сэргийлэх, ХЧА-ыг нөхөн сэргээх, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тусламж үйлчилгээний талаар сургалт сурталчилгаа хийх, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулна.

6.4.Шүүхээр ял эдэлж буй ялтанд ХЧА-н хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг Хорихын нэгдсэн эмнэлгийн Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрийг үндэслэн хорих байгууллагын харьяа аймаг (дүүрэг)-ийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хорих ангийн харьяа орон нутгийн нэгдсэн эмнэлгийн ЭХК-ын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэнэ.

6.5.Эмч, эмнэлгийн болон нийгмийн даатгалын байгууллагын мэргэжилтнүүд нь иргэн (даатгуулагч)-ий ХЧА-ыг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг хорогдуулах үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журмыг удаа дараа зөрчин, үйлчлүүлэгчтэй зүй бусаар харьцсан, бусдын гар харах, шан харамж авах, хууль бусаар төлбөртэй үзлэг шинжилгээ хийх, гар дээрээс эм худалдан авахыг шаардах, хуурамчаар хяналтын үзлэг бичих, шинжилгээний хариу гаргаж өгөх, цахим бүртгэлгүй үзлэг хийх зэргээр эмч эмнэлгийн мэргэжилтний болон төрийн албан хаагчийн, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

---oo0oo---